

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Шагдарсүрэн	Дугаар	L280
Оршин суугаа аймаг	Хөвсгөл аймаг	Оршин суугаа сум	Жаргалант сум
Төрсөн газар	Жаргалант сум	Төрсөн он	1928
Ажил мэргэжил	Сумын музейн эрхлэгч		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Арын хүрээ, Агьтын хурал, Хөнжлийн хурал	Сүм хийдийн дугаар	ХӨЖР 022, ХӨЖР 023, ХӨЖР 024
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 6-р сарын 5	Ярилцлага авсан хүн	Д .Мөнхбат



Хөвсгөл аймгийн Жаргалант сумын Арын хүрээ, Агьтын хурал, Хөнжлийн хурал

Мөнхбат: За манай судалгааны баг өнөөдөр 2007 оны 6 сарын 5-ны өдөр Хөвсгөл аймгийн Жаргалант сумын төв дэх сумын орон нутгийг судлах музейн үзвэрийн танхимд тус сумын өндөр настан эдүгээ далан нас сүүдрийг зооглож яваа Шагдарсүрэн гуайтай уулзаж байна аа. Ингээд Шагдарсүрэн гуайгаас Жаргалант сумын нутагт байсан Далай чойнхор вангийн хошууны хүрээ, хийд, хурал ном, сүм дацангийн тухай дараах хэдэн асуултыг тавьсан юм аа. За ингээд таниас асуух эхний асуулт бол сайн ноён хан аймгийн Далай Чойнхор вангийн хошууны томоохон хурал хийдийн газар болох Арын хүрээ гэж нэрлэгдсэн одоо энэ хүрээний тухай, энэ хүрээний түүхээс, шашин номын мандан бадарч байсан үеэс нь за мөн үйл ажиллагаа нь зогсож унтарч мөхсөн тэр цаг үеийг одоо эргэн дурсаж ярихгүй юу гэж хүссэн юм.

Шагдарсүрэн: Тэгэхээр би ер нь эхлээд, юунаас Тариатын хүрээнээс товчхон ярих нь зүйтэй байх л даа. Тариатын хүрээ бол хоёр мянга гаруй лам нартай, аа гурван зуугаад, тэр лам нарынхаа байртай нийлээд гурван зуугаад тийм байшин, барилгатай ийм байсан гэж байгаа юм. Аа Тариатын хүрээ бол найман засагч лам дамжсан

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

байгаа юм.Аа засаг ноён ч засаг Чоймбол гэдэг хүн, засаг Чоймбол, аа Лувсандондог , Лувсанбалдандамбийжанцан, Лувсандамба, Агваандамба, Агваанловсол, Лувсандондодов, Ригдэлбүрилгү гэж.Ийм найман гэвш лам Тариатын хүрээнд ирж байсан гэж байгаа юм.За Ригдэлбүрилгү гэгээний талаар бас нэлээн их сонин юм байдаг, Ригдэлбүрилгүгийн талаар. Энд ирээд ер нь тэрүүгээр газар нутаг сонирхоод явж байсан чинь нэгэн хүн одоо бүү үүрчихсэн яваад, тэгээд нэг анчныг алаад, тэгээд өнөөхийгээ гал түлээд шараад идчихлээ гэнэ ээ.Тэгээд өнөөх чинь аа тэр булгийн тэнд байж байснаа, булгаас ус уугаад тэгээд дороо унтаад өглөө гэнэ.Тэгэхээр нь тэр гавш лам бодсон гэж байгаа юм, үгүй ээ энэ ер нь яагаад яагаад тэгдэг юм бол гэсэн, аа энэ чинь ерөөсөө энүүнийг идсэн хүн бол ингээд ус уусан хүн үхнэ гэж унтаж болохгүй юм байна гэж.Тэгж явж байсан гэж байгаа юм.Тэгээд цааш нь ярих уу, болих уу.

Мөнхбат:Одоо энэ Арын хүрээний тухай, одоо бас түүхээс нь та жаахан тодруулаад яриад өгөхгүй юу?

Шагдарсүрэн: За Арын хүрээ бол ерөөсөө юу юм билээ.Гэмпэлдорж ноёны үед л анхан байгуулагдсан юм билээ. Аа тэгээд Арын хүрээг байгуулаад, Арын хүрээ чинь нөгөө хошуу хүрээний үүрэг бас хэсэг гүйцэтгэж байсан юм билээ.Аа Тариатынхаа хүрээн дээр яадаг болгосон юм.Аа харин Тариатынхаа хүрээн дээр бол засаг захиргааны нэгж нь тэндээ байсан юм гэнэ лээ.Аа яахав, таван зуу гаруй лам нартай байсан гэсэн.Аа тэгээд 1937 оны эсэргүүний үед тэр урд талын тэр шар ширэнгэ , тэндээс одоо буудаад, тэгээд одоо ерөөсөө тэр юу нь, зарим дээврээсээ энэ тэр юмнууд нь унаад, ингээд байхад л хурлаа хийгээд байсан гэж байгаа.Тэгээд л тэндээсээ юу, урд битүү нүүдэл талаад зарим лам нар нь зугтаад гарсан.заримыг нь ерөөсөө тэнд нь алчихсан.Тэгээд тэр мандраагийн сансан дээр багтахаа байчихсан, тэгээд л ерөөсөө ингээд л үхэр тэрэглээд л аваачаад тавиад байсан. Мандраагийн сансан гэж, Арын хүрээний сансан л даа.Тэнд багтахаа байсан гэж байгаа юм.За хамгийн сүүлчийн юу нь болохлээр зэрэг, даа лам нь болохлээр зэрэг Ядамжав цорж гэдэг хүн юм байна лээ.Аа Ядамжав цорж бол баригдаад явахдаа бол хэлтэст байхад нь бариад явсан.Тэгэхдээ бол ял эдлээгүй, тэгээд Тариатын хүрээ орж чадаагүй шахуу өөд болчихсон юм билээ, тэр юун дээр.За манайд бас нэг ийм байсан байгаа юм аа. Хүрээний дацан нь бол юу юм л даа, алтайдын дацан нэг нь байгаа юм.Аа бэлчирийн хөнжлийн адгийн дацан, энэ чинь дөрвөн дацантай байсан юм байна ш дээ. Дашпэлжээлин, Арцат эх...

Мөнхбат: За Тариатын хүрээний салбар Арын хийд гэж алдаршсан энэ хийдийн талаар товчхон мэдээлэл өгж байна.За үүний дараа одоо өнөөдөр Жаргалант сумын төвд байх Хөнжлийн дуганы тухай таньд одоо ямар мэдээлэл байна вэ?

Шагдарсүрэн: За энэ чинь ийм л юм билээ л дээ.1938 онд л оройг нь тайраад л , тайрсан юм байна лээ. За тэгээд Арын хүрээ, Дүүрэгчхайн хүрээнээс ирж хурал хурдаг.Цаг үеийн хуралтай, байнгын хуралгүй ийм байсан юм байна лээ. За тэгээд энд бол юу байгаа юм аа, энэ чинь анхан бол ерөөсөө гэр дуган байсан байгаа гэж байгаа.Тэгээд гэр дуган байж байгаад, модон дуган нь Хөнжлийн голын яг Идэр, хөнжлийн голын бэлчирт байж байгаад бариад, тэгээд тэр нь бол үерт явчихсан гэж байгаа юм.Үерт урсаад...

Мөнхбат: Нэг нь явсан гэж байгаа, тийм ээ?

Шагдарсүрэн:Тийм.Тэгээд зайлуулаад энд барьсан юм гэнэ лээ.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Мөнхбат: Голын эргээс л холтгосон , тийм ээ?

Шагдарсүрэн: Тийм.За дуганаа бол энэ Дуган дардагийн агүйд аваачиж, өвөл. болохоор дарчихдаг.Зун болохоор авчраад барьдаг, тийм байсан.Аа тийм учраас энд Дуган дардаг гэж агуй байсан, газар бий л дээ, нэртэй газар.За эндхийн ер нь юмнуудыг бол бурхан энэ тэр юмнуудыг бол маш сүйдсэн.Тэр нь намайг сургуульд байхад энэ Таягт цагаан гээд нэг жижигхэн булан байдаг.Тэрний яг тоглолтын тайзан дээр эвдэрхий хэмхэрхий бурхан, зарим нь бүр тав, зургаан настай хүүхэд сууж байгаа юм шиг тийм бурхнууд байдаг байсан.За шовх Дамдинсүрэн гуай бол зарим юмыг ,энүүнийг , энэ Арын хүрээний юмнуудыг энэ юунд Алагбуланд аваачиж тавьсан байх гэж ярьдаг. Аа ар тээлийн, биш Эрдэнэ тээлийн арын модны хонгилд хийсэн байх гэж Махгарлаа гуай бас тэгж ярьдаг байсан, ээ бурхан гэгээн төр минь.Арван хоёр тэмээнд ачаад явчихсан юм гэнэ лээ, гэж ингэж бас хуучилдаг байсан.За хоргын гэр хаднуудад хийсэн байж бас болзошгүй гэж бас Дамдинсүрэн гуай ярьдаг байсан.

Мөнхбат: Тэгэхээр энэ юу, Хөнжлийн дуганаас үлдсэн, хоёр дуганаас үлдсэн одоо энэ нэг том дуган бол их том, маш том.Ер нь бүрэн бүтэн байдлаараа бол энэ хавьд үлдсэн, яг хийц загвараараа үлдсэн дуган юм шиг бид нарт санагдсан.Тэгээд бид нар ингээд хэмжилт хийж үзээд , дуганы барилга зохиомжийг харахад ерөөсөө л эртний Дорно дахины, буддын уран барилгын арга барилаар, тэр агуулгаар баригдсан, тийм одоо эртний хэлбэр маягаар хийсэн нь харагдаж байна лээ.Тэгэхээр тэр эндээс нэг сонирхолтой нь тэр дуганы одоо гадна талын тулгуур багана модууд, тэр одоогийн барилгаар тэр пундаментийн үүргийг гүйцэтгэж байгаа тэр суурь одоо том пүнз моднуудын тэр өргөний диаметрууд бол үндсэндээ нэг тавиас тавин тав, жаран см шахуу диаметртэй ийм өргөн бүдүүн модоор бол яс модыг нь зангидаж хийсэн байсан.Тэгэхээр энэ их бат бэхээс гадна, энд ер нь хадаас бараг ороогүй, дандаа монгол мужааны тийм углуургын аргыг голлож барьсан бололтой юм гэж санагдсан. Тэгэхээр энэ барилгын одоо хийц маягийн талаар та одоо өөрийн бодож санаж явдаг сонссон зүйлээсээ ярьж өгнө үү?

Шагдарсүрэн: Энийг бол ерөөсөө яасан гэж байгаа ш дээ, бүр эхнээс нь аваад ярихад, монголын өнөө нэг оньсон арга бий ш дээ, одоо Түмэнэлзийн яагаад байгаа. Яг тийм аргаар л одоо чагтлаад, тэгээд л аль ерөөсөө заахыг нь заагаад л углуургадахыг нь углуургадаад л, тэгж дан угсарч бол ерөөсөө ноён нуруугаар нь зангидаж ерөөсөө л тэгж тогтоосон гэж байгаа ш дээ.Энэ чинь хоёр давхар байсан гэжү байгаа ш дээ. Тэгээд нэг давхрыг нь бол тэр гучин найман унь даагаад хийчихсэн.Тийм гэж байгаа юм.Энүүний чинь урд их хоёр том хүрд байсан гэж байгаа юм.Тэгээд л зүгээр эргүүлдэг.Аа мөн юу гэхлээр зэрэг зуун найман жижиг хүрд байсан гэж, ингээд л алгадаад яваад байдаг.Аа тэгээд энэ чинь дүгтэй байсан гэж байгаа юм.Өөрөөр хэлбэл Жанцанхорол юутай, дүгтэй.Тэр дүгтэй дуган гэдэг чинь бас их том үүрэгтэй байсан юм байна л даа.

Мөнхбат: Та тэгэхээр та бол одоо энэ нутгийн, энэ нутгийндаа бүр тэр хуучнаар Дүүрэгчийн хүрээ буюу академич Ренчин гуайн сүм хийдийн нэрсийн жагсаалтад Мандахын хийд нэртэйгээр нэрлэгдэж орсон тэр Дүүрэгчийн хүрээний тухай сайн мэддэг, тэрний түүх судрыг одоо нэлээн онцолж судалсан, холбогдох материалыг цуглуулсан хүн гэж ингэж сонссон.Тэгэхээр тэр Дүүрэгчийн хүрээ маань өнөөдөр засаг захиргааны

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

хуваарлилтаар Хөвсгөл аймгийн Галт суманд, Галт сумын нутагт харъяалагддаг болов чиг тухайн үеийн засаг захиргааны нэгжийн хуваарлилтаар одоо энэ Тариатын Ар хамжлага буюу Хөвсгөл аймгийн Жаргалант сум, Галт сумыг хамарсан ийм нутаг дэвсгэртэй хошууны томоохон бас хурал номын газар байжээ.Тэгэхээр энэ Дүүрэгчийн хүрээ, өнөөдөр Мандахын хүрээний энэ үүх түүхээс та бидэнд сонирхуулж ярьж өгнө үү?

Шагдарсүрэн: За энэ хүрээний лам нар нь бол яахав, гурван зуу орчим лам нартай байсан юм шиг байгаа юм.Тэгээд хоёр зуун арваад жил болсон юм шиг байгаа юм, энэ хүрээ.

Мөнхбат: Гучин долоо, гучин найман оноос өмнө ш дээ, тийм ээ?

Шагдарсүрэн:Тийм, тэгээд энэ бол тийм Мандахынхаа аманд байгуулагдаад арван хоёр жил болсон.Тэгээд тэнд өвчин энэ тэр гараад тэгээд Жүгэндэрийн аманд энийг зайлуулсан юм гэж байгаа юм.За энэ хүрээний хамгийн сүүлчийн, сүүлчийн тахилч нь болохоор гэрэг...Хамба нь болохоор зэрэг тэр Өвгөө лам гэдэг байгаа юм.

Мөнхбат: Өвгөө лам?

Шагдарсүрэн:Аа гэсгүй нь болохоор зэрэг халзангууд гэж ярьдаг, энэ долоон халзан гэж ярьдаг.Тэрний нэг Дандар гэдэг хүн гэсгүй нь байсан байгаа юм, хамгийн сүүлчийн.Аа тэр тэгээд Цагаан Магсар гэж байж байгаад, энэ хуралд саяхан орж байгаад өөд болсон.Тэр хүн тахилч нь байсан болов уу. Энийг бол Сүрэнжав дайчинхайн байсан гэж ярьдаг.Хоёр зуун арваад жил байсан гэхээр Сүрэнжав дайчинхайн үед биш л юм шиг санагддаг.Харин юу гэхлээр зэрэг, энэ Банди дүүрэгчийн үед болов уу.Ер нь Дүүрэгчхай гэсэн учраас, дүүрэгчхай хүрээ гэсэн учраас, аа дайчинхай гээгүй ш дээ.Тийм учраас Банди дүүрэгчхайн үед нь байгуулагдсан болов уу гэсэн, миний бодлоор тийм таамаг байдаг юм.За лам нар нь хоорондоо таарахаа байгаад Нүхтийн хүрээнд Шинэ идэр лүү лам нар тасарсан гэж, цаашаагаа.Багшийн яриатай.Тэрийг бол Дайданзан гэдэг дал гарсан хүн, Айнамын Дайданзан гэдэг хүн надад быас тэгж хуучилж байсан.За шүүхийн нарийн бичгийн дарга байсан Нямжанцан гэдэг хүн Мөрөнд байсан юм.Мөрөнгийн хүрээнд хурал хурж байгаад явсан.Тэр хүн бас надад, тэр хоёрын үг нийлж байсан.Дүүрэгчийн хүрээнээс Шинэ Идэрийн Нүхтийн хүрээ тасарсан.Лам нар нь хоорондоо таарахаа байгаад, тэгэхээр Нүхтийн хүрээ бол сүүлд нь байгуулагдсан.Ийм л юм билээ.

Мөнхбат: Одоо би танаас асууна аа.За тэгэхээр Хөвсгөл аймгийн Жаргалант сумын гуравдугаар багийн нутаг Агьтийн хурлын тухай одоо энд ярилцлага хийгдэх гэж байна.Тэгэхээр номч мэргэн, академич Ренчин гуайн сүм хийдийн жагсаалтанд Аягатын хүрээ гэж ингэж тэмдэглэгдсэн байдаг.Тэгэхээр энийг бол одоо энэ Жаргалант сумын нутагт Аягат гэж газар ус ч алга. Аягат гэж нэрлэгдсэн хурал ном, хүрээ хийдийн газар ч байхгүй байна.Тэгэхээр энийг бол одоо нутгийн өндөр настангууд ярилцаж байгаад энэ бол одоо Аягат биш, Агьтийн хурлыг одоо ингэж ташаарч бичсэн байна аа гэж бид бүхэн санал нэгдээд ингээд Агьтийн хүрээний тухай дараах сурвалждагыг хийсэн юм аа. За ингээд Шагдарсүрэн гуайгаас та яг одоо тэр нутгийн хүн юм байна.За одоо тэр Агьтийн хүрээ маань Шархүүгийн өвөлжөө гэдэг газар, энэ газар байдаг юм байна.Тэгэхээр энэ одоо хурал номын газрын тухай үүсэл, хөгжил одоо мандан, бадрал тэгээд мөхлийн тухай ярьж өгнө үү?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Шагдарсүрэн: За Агьтийнхны , Цагаан номон хааны дуган гэж байгаа юм л даа. За энэ бол ер нь үндсэндээ 1830-аад оны үед л Тариатын хүрээнээс Дондог гэдэг хүн ирсэн гэж байгаа юм. Дондог гэдэг хүн, за ингэхдээ энд бол Их номон хаан гэж аа Жигмэддамба, Бага номон хаан, Ихнасан ийм хүмүүсүүд ирээд. Тэгээд тэнд ирээд, тэр ард талын ууланд нь хаданд нь Майдар, Зонхов, Шагждүв одоо ийм гурван бурхан зуруулаад. Тэгээд баруун талын нь хамар юун дээр, гүвээн дээр юу гэдэг, Очирваань гэдэг бурхан зуруулсан байсан гэж. Тэгээд энэ бол яахав зүгээр тийм байнгын хуралтай биш, цаг үеийн хуралтай. Нүхтийн хүрээ, юу хоёроос ирж хүмүүсүүд нь хурдаг ийм байсан гэж байгаа юм. За хамгийн сүүлд, харин тахилч нь бол байнга байдаг. Аа тахилч нь халзан хэмээх Шарав гэлэн гэдэг хүн, хамгийн сүүлчийн тахилч нь. Тэрнийг бол би бүр мэднэ л дээ.

Мөнхбат: Нөгөө долоон халзангийн нэг үү, үгүй юу?

Шагдарсүрэн: Биш. Нэг тийм хүн байдаг байсан юм. За энэ хүрээ бол юу гэх дээр зэрэг, гол нь ...юутай, Жамсран. Улаан сахиус гол шүтээн нь. За тэгээд хурлаараа бол гүнриг хурдаг, додор, чоймпил аа санжчогсом гэдэг номуудыг хурдаг байсан гэж байгаа юм. Энэ санжчогсом гэдэг номыг зуун жил хурсан гэж байгаа юм. Ерөөсөө яг зуун жил хурсан гэж. Аа энэ дуганыг бол 1938 онд Ядамжавын Батбаяр гэдэг хүн шатаасан гэж байгаа юм.

Мөнхбат: Бас л тэгээд нөгөө цагийн байдал цэвүүн болох үеэр л?

Шагдарсүрэн: За тэгээд энд тэгээд тэр бурхныг 1917 онд Нүхтийн хүрээнээс Лүндэг гэдэг ламыг залж ирж сэргээж ирж байсан гэж байгаа. Энийг бол тэр наян нас хүрсэн Бадраа гэдэг ээж гүай ярьдаг байсан. За энд хүрж байсан яг нутгийн хүн гэх юм бол тэр Дэмчигжав гэдэг хүн бол ер нь ламын хэргээр биш баривчлагдаад явсан. Одоо цагаатгагдаагүй байдаг юм. Аа харин тэр Сандуйжав гэдэг хүн бол, ловон гэдэг бол цагаатгагдсан. Аа цагаатгагдахдаа бол 1996 оны 7 сарын юугаар магадлангаар билүү цагаатгагдсан юм билээ.

Мөнхбат: Би нэг таныг тамхиа нэрэхээс өмнө ганцхан асуулт асуугаадахая. За таны одоо энэ магадгүй сүүлийн хорь гучин жилийн хөдөлмөр шингэсэн, бүтээл зүтгэл шингэсэн энэ Жаргалант сумын орон нутгийг судлах музей бол үнэхээр одоо газар нутаг, байгалийн баялаг, угсаатны зүй буддын соёлын түүх талаасаа их олон сайхан баялаг үзмэртэй, манай орны хөдөө сумдад нэг их элбэг тааралдаад байдаггүй ийм сахйан музей байна. Тэгэхээр энэ музейн үзмэрүүдийг ингээд сонирхож байхад, энэ музейд энэ нутаг хошууны газар нутаг дээр үйл ажиллагаа явуулж байсан одоо Арын хүрээ, Агьтийн хүрээ, Хөнжлийн дуган, Мандлын хурал гэх мэтчилэнгийн энэ хурал номын газруудад хэрэглэгдэж ашиглагдаж байсан шашин номын зан үйлтэй холбоотой одоо эд хэрэглэлүүд бол ном судрууд цөөнгүй байна аа. Тэгэхээр эндээс танай энэ дотор байгаа үзмэрүүдээс одоо дээр энэ миний хэлсэн энэ хүрээнүүдэд хэрэглэгдэж байсан хамгийн онцлог, ховор магадгүй цорын ганц хувь энэ тэр байх тийм одоо үзмэрүүд байвал та онцлог үзмэрүүдээсээ товч ярьж өгнө үү?

Шагдарсүрэн: Онцлог үзмэрүүдээс гэх юм бол энэ Пэлжээлин сүмийн жасын тогоо байсан гэж хүрэл тогоо. Тэр бол ер нь нэг зуу шахуу литрийн багтаамжтай ийм нэг хүрэл тогоо байдаг юм. Аа Дүүрэгчхайн хүрээний тэр тулга. Найман угалзтай маш гоё тулга. Ийм тулга байдаг юм. Аа гурван сэлэм, бага дунд их гарын. Энэ сэлэм бол олдохгүй ховор бүтээл. За тэр бадарчингийн хавчиг бүүрэгний, араг араам нь байгаа юм даа. Тэр бол яг их

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

олдохгүй ховор бүтээл байгаа юм.За ер нь яахав, сайн мэдэхгүй юун дээрээс нь үзэх юм бол зуун тавиад жамчтай ном.Тэр бол ер нь их л ховор юм бий л гэж боддог, би л тэрэнд...

Мөнхбат: Энэ л хүрээ хийдэд бас ашиглагдаж байсан?

Шагдарсүрэн: Ашиглагдаж байсан, ийм юм байгаа юм.

Мөнхбат: Тэгэхээр би түрүүн ажиглалаа л даа. Энэ ороод ирэхэд таны одоо орон нутгийг судлах музейн байшингийн үүдний довжооны хоёр талд боржин чулуугаар ухаж маш одоо уран гоёор хийсэн бурхны гүнгэрваа маягийн тийм одоо хоёр чулуун хийц байна.Тэгэхээр одоо энэ мөн л одоо эрт цагийн түүхийг агуулсан ийм эд өлгийн зүйл гэж ажиглагдсан. Тэгэхээр энийг та одоо чухам аль хүрээний туурин дээрээс ямар замаар авчирсан юм бол? Энэний түүх судар гэж танд байна уу?

Шагдарсүрэн: Энүүний түүх судар гэвэл энэ ёстой Арын хүрээн дээрээс л ирсэн зүйл байгаа юм.Арын хүрээн дээрээс ирсэн энэ чулууг бол энэ чулуунуудыг бол хэн Пүрэвсүрэн дарга байхдаа, Далхын Пүрэвсүрэн гэдэг дарга байхдаа машинаар ачиж авчирч энэ музейн урд талд ингэж байрлуулж байсан гэж байгаа юм.Ер нь манай суманд бол Пүрэвсүрэн дарга хэн хоёр шиг л, Зинэмидир дарга шиг л тийм соёлын өвийг хамгаалах , соёлын өвийг цуглуулах талаар оролдож байсан хүн сумын дарга нар дотор, сум нэгдлийн дарга нар дотор байгаагүй дээ.

Мөнхбат: За ингээд өнөөдөр далан насыг зооглож яваа ч гэсэн бие сэтгэлийн хувьд...

Шагдарсүрэн: Би нэг юм ярьчихая.

Мөнхбат: За.

Шагдарсүрэн: Тэр Махгардаа гэдэг хүн, Махгардаа тэр хэний, Банчилын Махгардаа гэдэг хүн энэ Дүүрэгчхайн хүрээний юмнуудыг бол агуй хонгил хадан дээр их хийж, их хамгаалсан хүн шүү дээ, их онцлогтой,Тэгээд өөрөө баригдаад арван жил шоронд яваад тэгээд шоронд яваад алтны уурхайн, энэ Ерөөл бороогийн уурхайд ажиллаж яваад тэгээд арван жилээ дуусгаад, тэгээд нутагтаа ирээд тэгээд энэ музейг байгуулахад одоо дөч гаруй юмнууд авчирч энэ музейд өгсөн гэж байгаа юм. Ер нь энэ ховор юмнуудыг бол Махгардаа гуай л өгсөн гэж байгаа ш дээ, ерөөсөө.Хадгалж байгаад л , хад манд тавьж байгаад л авчирч өгсөн, тэр бол их мундаг хүн. Тэгээд тэрний одоо арван жил яасан, тэгж хэлмэгдэж зовсон төлбөр нь бол олдоогүй.Ач зээ нар нь бол одоо ч бий л дээ.Ийм л байдаг юм.Тэр их онцлог хүн.

Мөнхбат: За ингээд өнөөдөр далан насыг зооглож яваа ч сэтгэл биеийн бэрхшээл зовлонг үл умартан монголын түүх соёлын дурсгал, газар орныхоо түүх буддын соёлын арвин их түүхийг одоо бүтээж, цуглуулж хойч үедээ өвлүүлэх, гадаад дотоодынхонд сурталчилах энэ их үйлсийг гүйцэтгэж яваа өндөр настан Шагдарсүрэн гуайдаа таньд маш их баярлалаа.Таны цаашдын ажил амьдралд улам их амжилтыг хүсэн ерөөе. Та бид хоёрын энэ ярилцлага, таниас одоо манайд өгсөн, монголын сүм хийдийн түүхэн товчоо гэсэн судалгааны энэ төсөлд өгсөн үнэтэй мэдээллүүд бидэнд маш их хэрэг болно оо гэсэн ийм одоо дүүрэн итгэл сэтгэлээр энэ ярилцлагаа төгсгөө. Танд баярлалаа.

Шагдарсүрэн: За баярлалаа, би ч.